



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 10 75, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: fiscalcouncil@parliament.mn

2026.09.02 № 72

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА Н.НАРАНБААТАР ТАНАА

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹ дүгээр зүйлийн 16^{1.5.2} дахь заалтыг үндэслэн гаргасан дүгнэлтийг хүргүүлж байна.

Хавсралт // хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГА

Ж.ДЭЛГЭРСАЙХАН





**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛ БОЛОН ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ ДҮГНЭЛТ**

УЛААНБААТАР ХОТ
2026 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 08 дугаар сарын 20-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай” хуулийн төсөл болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.5.2 дахь заалтыг үндэслэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (ТТБЗ) дүгнэлт гаргалаа. Бид дүгнэлтдээ өргөн мэдүүлсэн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд тусгагдсан “Төсвийн тусгай шаардлага”-д нийцсэн эсэх, 12.1, 12.3 дугаар зүйлд тусгагдсан “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд дараах үзүүлэлтийг тусгана”, мөн “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн агуулга”-тай нийцсэн эсэх, Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тусгагдсан төсөв боловсруулах шаардлагад нийцтэй эсэхэд анхаарсан болно.

Нэг. Төсвийн бодлого, дунд хугацааны макро эдийн засгийн төлөв байдал


1. Бодит эдийн засгийн өсөлт эхний хагас жилд 7.7 хувьд хүрсэн хэдий ч оны сүүлийн хагаст буурахаар байна. Нэрлэсэн ДНБ 2026 оны эхний хагаст 52.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 30.4 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 16.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар тус тус өсжээ. Уул уурхай, тээврийн салбар эрчимжиж, барилга, эрчим хүчний салбарын өсөлт тогтвортой үргэлжилсэн бол ХАА-н өсөлт өндөр суурийн нөлөөгөөр саарсан ч эерэг өсөлтөө хадгалсан байна. Ийнхүү эдгээр салбар эдийн засгийн өсөлтийг голлон дэмжсэн бол худалдааны салбарын агшилт эдийн засгийн өсөлтийг сааруулах нөлөө үзүүлжээ.

Хүснэгт 1. Монгол Улсын эдийн засгийн өсөлт, 2020-2026 оны эхний хагас жил, өмнөх онуудын мөн үетэй харьцуулсан хувиар

Үзүүлэлт	2020Н1	2021Н1	2022Н1	2023Н1	2024Н1	2025Н1	2026Н1
ДНБ	-9.0	6.3	2.0	6.7	5.7	5.6	7.7
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.7	-0.8	1.8	-1.7	-3.9	3.6%	1.4
Уул уурхай, олборлолт	-4.6	2.6	-4.0	3.9	1.8	0.1%	3.9
Боловсруулах үйлдвэрлэл	-0.4	0.7	-0.1	0.1	0.2	0.3%	0.1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.1	0.3	0.2	0.1	0.2	0.3%	0.2
Барилга	0.0	-0.9	-0.1	0.0	0.3	0.4%	0.2
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	-1.6	0.5	1.4	0.8	1.2	-0.7%	0.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	-1.3	0.3	-0.6	1.9	0.8	-0.6%	0.8
Мэдээлэл, холбоо	0.1	0.5	0.4	0.4	0.6	0.6%	0.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	-1.3	0.1	1.5	0.7	2.3	1.4%	0.8
Бүтээгдэхүүний цэвэр татвар	-1.6	3.0	1.7	0.4	2.1	0.2%	0.1

Эх сурвалж: УСХ, 2026 он

Зураг 1. Эдийн засгийн өсөлт, түүний бүрэлдэхүүн оны эхний хагас жилийн байдлаар



Эх сурвалж: YCX 2026 он

Эдийн засгийн өсөлтийн 2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийг 5.7 хувь байхаар төсөөлсөн байна. Салбараар авч үзвэл, нүүрс, зэсийн олборлолтын эрчим хадгалагдсанаар уул уурхайн салбар эдийн засгийн өсөлтийг голлон дэмжих төлөвтэй байна. Үүнийг даган тээврийн салбар мөн эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлөх бол орон сууц, дэд бүтцийн бүтээн байгуулалтын идэвхжилтэй холбоотойгоор барилгын салбар эерэг хувь нэмэр оруулна гэж тооцжээ. Харин өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ өсөж, дотоод эрэлт удааширч байгаатай холбоотойгоор худалдааны салбар оны эхний хагаст агшсан бөгөөд уг хандлага оны туршид үргэлжлэх төлөвтэй байгаа нь эдийн засгийн өсөлтийг сааруулах нөлөө үзүүлэхээр байна.


Гадаад эрэлт тогтвортой хадгалагдаж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын өсөлт үргэлжлэх төлөвтэй байгаа нь цэвэр экспорт эдийн засгийн өсөлтийн гол дэмжлэг болох хүлээлт бий болгож байна. Түүнчлэн орон сууцны барилгын бүтээн байгуулалтын хүрээ тэлж нийт хөрөнгийн хуримтлал эдийн засгийн өсөлтийг дэмжинэ. Харин зээл олголтын хэмжээ өнгөрсөн оны түвшинд байж эдийн засгийн үйл ажиллагааны дотоод идэвхийг дэмжих хэдий ч инфляцын өсөлт үргэлжлэн хадгалагдсанаар эцсийн хэрэглээ саарах төлөвтэй байна.

2. Инфляцын түвшин 2026 оны 7 дугаар сард 13.0 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 4.9 нэгж хувиар өссөн бөгөөд оны төгсгөлд Төв банкны зорилтот түвшнээс өндөр гарах хүлээлттэй байна. Үүнд мах (52.4%), төмс (87.7%)-ний үнийн огцом өсөлт болон дэлхийн зах зээл, геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалсан шатахууны үнийн өсөлт (19.2%) голлон нөлөөлсөн. Инфляц сүүлийн хагаст Төв банкны зорилтот түвшнээс өндөр хадгалагдахаар байгаа бөгөөд Төв банк бодлогын хүүгээ 12 пунктээс 12.5 пункт хүртэл өсгөж чангаруулсан. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 49.0 их наяд төгрөгт (жилийн өсөлт 15.9%) хүрч, нийт зээлийн үлдэгдлийн 73 хувийг бизнесийн, 27 хувийг хэрэглээний зээл бүрдүүлж байна. Гэсэн ч бизнесийн болон хэрэглээний зээлийн аль алиных нь өсөлтийн хурд саарч, зээлийн өсөлтийн эрч суларсан байна.

3. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл оны эхний хагаст 1.2 их төгрөгийн алдагдалтай гарсан бөгөөд сүүлийн хагас жилд төсвийн орлого төлөвлөснөөс буурсан тохиолдолд

алдагдал нэмж өсөх дүр зурагтай байна. Төсвийн орлогын өсөлтөөс илүү төсвийн зарлагын өсөлтийн чиг хандлага нь төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалтай байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Зураг 2. Төсвийн орлого, зарлагын өсөлтийн төсөөлөл 2026-2029 онд



Монгол Улсын 2026 оны төсвийн тодотголоор орон нутгийн төсвийн урьд оны ашиглаагүй үлдэгдлээс нэг их наяд орчим төгрөгийг зарцуулахаар хууль эрх зүйн зохицуулалт хийж, төсвийн нийт зарлагыг 998.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж **33,978.0 тэрбум төгрөг** (ДНБ-ий 33.2%) болгож байгаа нь төсвийн нийт зарлагын ДНБ-нд эзлэх жинг 1 пунктээр нэмэгдүүлэхээр байна. **Төсвийн тодотгол нь бодлогын макро эдийн засгийн нөхцөл байдлыг тогтворжуулахад чиглэсэн боловч тодорхой эрсдэлүүдийг дагуулахаар байна.** 2026 оны төсвийн тодотголд иргэдийн орлогыг хамгаалах болон стратегийн бүтээгдэхүүн, нефть, эрчим хүчний хангамж найдвартай хангах бодлого баримлаж байгаа нь өнөөгийн нөхцөл байдалд нийцтэй, тулгамдсан асуудлыг шийдэхэд чиглэсэн үзэж байна.

4. Гадаад худалдаа ба төлбөрийн тэнцэл оны эхний хагас жил 566 сая ам.долларын ашигтай гарсан. Төлбөрийн тэнцэл ашигтай гарахад экспортын өсөлт, тэр дундаа зэсийн баяжмал, нүүрсний экспорт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Цаашид оны төгсгөлд нийт экспорт **19.0 тэрбум ам.доллар** (үүнд зэсийн баяжмалын орлого 7.2 тэрбум, нүүрсний экспорт 100 сая тоннд хүрэх төлөвтэй), нийт импорт **12.9 тэрбум ам.долларт** хүрэхээр тооцжээ. Энэ тохиолдолд гадаад худалдааны тэнцэл **6.1 тэрбум ам.долларын ашигтай** гарахаар байна. Төлбөрийн тэнцэл эхний хагас жилд ашигтай гарч, ГВАН 2026 оны 7 дугаар сарын эцэст **7.96 тэрбум ам.долларт** хүрч, өмнөх оны мөн үеэс **2.58 тэрбум ам.доллараар** өсөж, урсгал данс эхний хагас жилийн байдлаар **179 сая ам.долларын ашигтай гарсан** нь эерэг үзүүлэлт юм.

5. Монгол Улсын макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал гадаад, дотоодын нөхцөлөөс хамаарч эрсдэлтэй хэвээр байна. Эдийн засагт уул уурхайн олборлолт, экспортын тэлэлт, гадаад валютын нөөцийн өсөлт зэрэг эерэг талууд давамгайлж байгаа ч инфляцын өндөр түвшин, ХАА-н салбарын уналт, иргэдийн худалдан авах чадвар, эцсийн хэрэглээний саатал зэрэг нь эдийн засгийн тогтвортой өсөлтөд гол эрсдэл үүсгэж байна.

Хоёр. “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн тухай хуульд нийцсэн эсэх талаар


1. Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх. Өргөн мэдүүлсэн төсөлд 2026 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тн тутамд 8,341.8 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тн тутамд 133.7 ам.доллар байхаар өмнө нь төсөөлж батлагдаж байсан үнээр тооцсон нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.3-т заасан тодорхойлолтын дагуу тэнцвэржүүлсэн орлогыг тооцсон гэж үзэх үндэслэл болж байна.

2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2026 онд 2.0 хувийн, 2027 онд 1.5 хувийн, 2028 онд 1.0 хувийн алдагдалтай байхаар тусгасан нь тухайн төсвийн жилийн ДНБ-ий 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх хуулийн хязгаарт нийцэхээр байна. (Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах төсөлд 2024 оны 08 дугаар сараас хойш мөрдөгдөж байсан “Нэгдсэн төсвийн суурь тэнцэл ашигтай байх” гэсэн заалтыг хүчингүй болгохоор тусгасан.)

3. Засгийн газрын өрийн нийт хэмжээ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т “Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх” гэж заасан байдаг. Өргөн мэдүүлсэн төсөлд Засгийн газрын өрийн үлдэгдлийг 2026 он болон 2027-2029 онд ДНБ-ий 50 хувьд байхаар тооцсон нь хуульд заасан өрийн дээд хязгаараас 10 нэгж хувиар доогуур бөгөөд уг төсөл нь хуулийн шаардлагыг хангаж байна.

4. Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ. Нэгдсэн төсвийн нийт зарлага 2026 онд 8.4 хувиар, 2027 онд 7.4 хувиар, 2028 онд 5.8 хувиар өсөхөөр төсөөлсөн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлт нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлт болон өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджаас аль ихээс хэтрэхгүй байх” гэж заасан зохицуулалттай нийцэж байна.

Зураг 3. 2026 оны төсвийн зарлага, уул уурхайн бус салбарын өмнөх 12 жилийн дундаж өсөлтийн харьцуулалт



5. Урсгал зардал. Монгол Улсын 2026 оны төсвийн тодотголын төсөлд нэгдсэн төсвийн урсгал зардлыг 26,054.0 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд уг дүн нь тухайн жилийн ДНБ-ий 25.4 хувьтай тэнцэж байна. Энэ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд

заасан нэгдсэн төсвийн урсгал зарлага тухайн жилийн ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй байх тусгай шаардлагаас 4.6 нэгж хувиар доогуур байна. Иймд 2026 оны төсвийн тодотголын төсөлд тусгасан урсгал зардлын хэмжээ нь уг төсвийн тусгай шаардлагыг хангаж байна гэж дүгнэж байна.

6.Олон нийтийн хэлэлцүүлэг. Төсвийн тухай хуулийн 28¹.4-т “Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь олон нийтийн хэлэлцүүлгийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн хугацаанд энэ зүйлд заасан журмаар зохион байгуулна” гэсэн заалтын дагуу ЭЗХЯ-ны дэргэдэх “Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах төв”-д 2026 оны 08 дугаар сарын 07-ны өдөр 2027 оны улсын төсвийн төсөл болон Монгол Улсын 2026 оны төсвийн тодотголын төслийг олон нийтэд танилцуулж, нээлтэй хэлэлцүүлэг зохион байгуулсан нь хуулийн заалтыг хэрэгжилтийг хангасан гэх үндэслэл болж байна.

Гурав. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

ДХТХМ-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан дараах өөрчлөлтийг тусгасан байна. Үүнд:

1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг өөрчлөн найруулж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байхаар;
2. Мөн хуулийн 6.1.3 дахь заалтыг өөрчлөн найруулж, нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийг тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт болон тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байхаар;
3. Хуулийн 12.1 дэх хэсэгт заасан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтэд “нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ” болон “нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ”-г нэмж, төсвийн зарлагын өсөлтийн дээд хязгаар, хөрөнгийн зардлын дээд хязгаарыг дунд хугацаанд урьдчилан тодорхойлдог байхаар;
4. Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12, 4.1.13 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.9 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцохоор тус тус тусгасан байна.

Эндээс дүгнэвэл:


1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12, 4.1.13 дахь заалтыг өөрчлөн “нэгдсэн төсвийн суурь тэнцэл”, “нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ” гэх сүүлийн хоёр жил УИХ-ын түвшинд шүүмжлэл дагуулсан үзүүлэлтийг хүчингүй болгож, түүний оронд урьд өмнө нь мөрдөгдөж байсан “нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ”, “нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ” гэсэн үзүүлэлтүүдийг буцааж тусгасан нь улсын төсвийн нэгдсэн удирдлагын хяналтыг илүү тодорхой болгох зорилготой зөв зүйтэй алхам гэж үзэж байна. Ерөөс “төсвийн суурь тэнцэл”, “суурь зарлага” гэдэг нь олон улсын нийтлэг жишигт байдаггүй, 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Төсвийн тогтвортой байдлын тухай хууль-д нэмж оруулсан “дотоодын” нэр томьёо юм.

2. Хуулийн 6.1.2. дахь заалтад оруулах өөрчлөлтөөр ДНБ-ий 2 хүртэлх хувийн алдагдлыг зөвшөөрсөн нь Засгийн газарт хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх нэмэлт хөрөнгийн эх үүсвэр бий болох, эдийн засгийн хүндрэлтэй эсвэл гэнэтийн шок үүссэн үед төсвийн зарлагыг хумихгүйгээр эдийн засгийг дэмжих боломж харагдаж байгаа ч тэнцэл ашигтай байх шаардлагыг авч хаяснаар алдагдлыг нөхөх тусам улсын өр нэмэгдэж, ирээдүйд төлөх хүүгийн зардал өсөх, төсвийн зарлага эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг өсгөж, улмаар инфляцын дарамтад оруулах, алдагдалтай төсвөөр дамжин импортын хэрэглээ нэмэгдэж, гадаад валютын урсгал гадагшилснаар төгрөгийн ханш унах, цаашид төсвийн алдагдлыг гадаад, дотоод зээл, үнэт цаасаар санхүүжүүлсээр байвал эдийн засгийн ачааллыг нэмэгдүүлэх нөхцөл үүсэхээр байна.
3. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3. дахь заалтад оруулахаар тусгасан өөрчлөлт нэг талаас Монгол Улс шиг уул уурхайгаас хамааралтай эдийн засагт нийтийн жишгийг дагаж буй дэвшилттэй алхам мэт боловч Засгийн газарт төсвийн зарлагыг өсгөх илүү том эрх мэдэл, орон зайг хуулиар нээж өгч байгаагаараа анхаарал татаж байна. Өмнөх хуулиар урсгал зарлага ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй гэсэн хатуу хаалт байсан. Шинэ дүрмээр нийт зарлагын хэмжээ маш өндөр хувьд хүрэх, өсөлтийн хувь нь хуулийн шалгуурыг хангаж байвал зөвшөөрөгдөх тул төсөв хэт томрох, Засгийн газар цалин, тэтгэвэр, халамжийг эдийн засгийн бодит бүтээмжээс давуулан хяналтгүй нэмэх боломжтой болох, үүний улмаас хөрөнгө оруулалтын зардал танагдах, төр хэтэрхий том урсгал зардалтай болж, эдийн засаг дахь бүх нөөцийг өөртөө татаж, тогтвортой, өндөр цалинтай төрийн алба руу шилжих хөдөлгөөн ихсэж, эдийн засгийг авч явдаг хувийн хэвшлийнхэнд ажиллах хүчний хомсдол үүсэж, зээлийн олдоц муудан уул уурхайн салбараас хамааралтай “Голланд өвчин” гүнзгийрч, бусад баялаг бүтээгч салбарууд нурах зэрэг эрсдэл байна. Дашрамд, ТТБЗ-ийн зүгээс өмнө нь өгч байсан дүгнэлтдээ “Улсын төсвийн урсгал зардлын нийт зарлагад эзлэх хувь сүүлийн 3 жилийн дунджаар 75.2 хувь байгаа бөгөөд 70 хувиас дээш гарахыг улаан шугам давсан гэж үздэг. Энэ нь төсвийн орлого буурахад дагаад агших боломжгүй цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, нийгмийн халамж зэрэг зардал давамгайлах болсны дохио бөгөөд ойрын үед эдийн засагт хамгийн том сорилт болох шинжтэй байна” хэмээн дурдаж байсныг дахин сануулах нь зүйтэй гэж үзэж байна.
4. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12.1 дэх хэсэгт “Хөрөнгийн зардлын хэмжээ”-г төсвийн хүрээний мэдэгдэлд тусгайлан зааж өгснөөр Засгийн газар хөрөнгө оруулалтын зардлыг тэлэх, төсвөөс давсан том төслүүд батлах боломжийг хязгаарлаж, дунд хугацааны хяналтыг чангаруулахын сацуу нийт зарлагын өсөлт, хөрөнгийн зардлын дээд хязгаар тодорхой болсноор эдийн засгийн мөчлөг дагасан хэт савлагаатай хөрөнгө оруулалт хийхийг хуулиар хаах боломж бүрдэж байна. Түүнчлэн нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээг хуульчлан зааж өгснөөр орон нутаг төсвийн үлдэгдлийг дур мэдэн, хяналтгүйгээр зарцуулах эрхийг үндсэнд нь хязгаарлаж, нэгдсэн төсөв гэх малгай хязгаарлалт үйлчилнэ. Гэхдээ аль ч тохиолдолд хөрөнгийн зардлын зөвхөн хэмжээ (дүн)-г хязгаарлахаас бус, тухайн хөрөнгө оруулалт нь эдийн засагт үр ашигтай эсэхийг хянах чанарын үнэлгээ орхигдож, үр ашиггүй төслүүд хязгаарлалтын хүрээнд багтан санхүүжигдэх эрсдэл хэвээр үлдэнэ.
5. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5 дахь заалтыг хүчингүй болгох нь улсын төсвийг урт, дунд хугацааны бодлого, төлөвлөлтгүйгээр, зөвхөн тухайн үеийн

улс төрийн нөхцөл байдалд тохируулан төсвийг ойр ойрхон өөрчлөх (тодотгох) үүд хаалгыг нээж байна. Энэхүү гурван сарын хугацаа Засгийн газар эхлээд эдийн засгийнхаа боломж, хязгаарыг ДХТХМ-ээр тодорхойлж, түүндээ нийцүүлэн жилийн төсвөө чанартай боловсруулахыг шаарддаг, хамгаалалтын механизм байсан. ОУВС-гаас Монгол Улсад зөвлөж, туслахдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг чанд мөрдөж, төсвийн дүрмүүдээ хатуу сахихыг үргэлж шаарддаг. Энэхүү хамгаалалтын заалтыг устгаснаар Монгол Улс институцийн хувьд ухарсан алхам хийлээ гэж дүгнэх магадлалтай, эдийн засагт хүндрэл үүсэж, Монгол Улс дахин санхүүгийн тусламж, хөтөлбөр хүсэх шаардлага гарвал ОУВС-гийн тавих шалгуур, нөхцөлүүд улам хатуурах эрсдэлтэй. Мөн Олон улсын зээлжих зэрэглэлийн агентлагуудын үнэлгээнд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Энэхүү заалтыг хүчингүй болгох нь зүгээр нэг техникийн зохицуулалт биш, харин Монгол Улс сонгуулийн мөчлөг, улс төрийн амлалтад зориулж төсвийн сахилга батаа золиослоход бэлэн байна гэсэн дохио өгч урт хугацаандаа манай улсын гадаад нэр хүнд, хөрөнгө оруулалтын орчин, санхүүгийн тогтвортой байдалд хохирол учруулах эрсдэлтэй юм. Түүнээс гадна энэ заалтыг хүчингүй болгосон тохиолдолд төсөв тодотгох болгонд ДХТХМ-ийг өөрчилдөг өмнөх жилүүдийн буруу жишиг давтагдаж, төсвийн сахилга бат сулрах, төсвийн зарлагыг өсгөх суурь нөхцөлүүд бий болохыг хуулиар зөвшөөрсөн хэрэг болно. Өнгөрсөн жилүүдэд төсвийн тодотгол хэмээх арга хэрэгслийг өндөр давтамжтай, тухайн жилийн төсвийн тухай хуулийг шинэчлэн найруулах хэлбэрээр хэрэглэж ирсэн буруу жишгээс үүдэн төсөв, тодотгол хоёрт нэгэн ижил шаардлага тавих нөхцөл бүрдсэн бөгөөд тус заалтыг хүчингүй болгосноор төсөвт тавигддаг “хүрээг баталснаас багадаа 3 сарын дараа төсөв батлагддаг” жишиг төсвийн тодотголд мөрдөгдөхгүй байх, жил бүрийн 6 дугаар сард батлагддаг ДХТХМ байнга өөрчлөгддөг байх нөхцөл үүснэ. Улмаар өмнөх жилүүдийн жишгээр хүрээ нь төсвөө даган өөрчлөгдөх, төсвийн төлөвлөлтийг үндэслэл, тооцоо сайтай хийх замаар шаардлагагүй тодотголыг бууруулах чиглэлд хийгдэж буй алхамаас татгалзсан болно гэж үзэж байна.

Энэ бүхнээс харвал, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд оруулах өөрчлөлтийг хангалтгүй, дутуу боловсруулсан гэж үзэхээр байна.

Зураг 4. ДНБ, төсвийн зарлагын нэрлэсэн өсөлт (2010-2025 он)




Эх сурвалж: (ҮСХ, 2025)


Тухайлбал, ДХТМ-д нэмж тусгахаар санал болгож буй “нэгдсэн төсвийн зарлагын өсөлтийн хэмжээ”, “нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ” гэсэн тусгай шаардлагыг хэрэгжүүлэхийн тулд *нэгдүгээрт*, төсөв болон ДХТХМ-ийг хэлэлцэн баталж буй оны, *хоёрдугаарт*, тухайн төсвийн жилийн, *гуравдугаарт*, ДХТМ-ийн төсвийн төсөөлөлд тусгадаг тухайн төсвийн жилийн дараах хоёр жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий нэрлэсэн өсөлтийг урьдчилан таамаглах шаардлага үүсэж байгаа бөгөөд энэ тохиолдолд ДХТХМ-д “эрдэс баялгийн бус ДНБ-ий нэрлэсэн өсөлт” гэсэн үзүүлэлт шинээр оруулж, бусад үзүүлэлтийн хамт төсөөлөл боловсруулж, хэлэлцэн батлах хэрэгтэй болно.

Эндээс харвал 2010-2025 онд ДНБ-ны нэрлэсэн өсөлт дунджаар 18.3, төсвийн зарлагын нэрлэсэн өсөлт дунджаар 18.7 хувь байгаа бөгөөд нийт дүнгээрээ ДНБ 9.23 дахин, төсвийн зарлага 10.16 дахин өссөн байна.

Зураг 4. 2026 оны төсвийн зарлагын өсөлтийг уул уурхайн бус салбарын өмнөх 12 жилийн дундаж өсөлттэй харьцуулсан нь



Зураг 5. 2026 оны төсвийн зарлагын өсөлтийг уул уурхайн бус салбарын өмнөх ялгаатай жилүүдийн дундаж өсөлттэй харьцуулсан нь



Дөрөв. Дүгнэлт, зөвлөмж

1. Эдийн засгийн эрсдэл өндөр хэвээр байхад төсвийг тэлж байна. 2026 онд эдийн засагт уул уурхай, экспортын тэлэлт, гадаад валютын нөөцийн өсөлт зэрэг эерэг талууд ажиглагдаж байгаа ч дотоод инфляцын өндөр түвшин, ХАА-н салбарын уналт, иргэдийн худалдан авах чадвар болон эцсийн хэрэглээний саатал зэрэг нь эдийн засгийн тогтвортой өсөлтөд гол эрсдэл үүсгэж байна. Өсөлт тогтвортой бус байхад ДХТХМ-ийг өөрчлөх, төсвийн зарлагыг тэлэх нь эрсдэлтэй гэдгийг анхаарах шаардлагатай.

2. Төсвийн тусгай шаардлагууд тогтвортой бус хэвээр байна. Төсвийн тодотголын хамт төсвийн тусгай шаардлагыг 2024 оны 8 сар хүртэл мөрдөж ирсэн хэлбэрт шилжүүлж байгааг ТТБЗ дэмжиж байгаа ч тусгай шаардлагыг байнга өөрчлөх хандлага хэвшил болж байгааг анхаарах шаардлагатай. Мөн төсвийн тодотголын төсөл нь өмнө мөрдөж байсан тусгай шаардлагыг сэргээхээр өргөн мэдүүлсэн хуулийн төслийн тусгай шаардлагыг хангаж байгаа боловч хуулийн төсөл боловсруулсан ч одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа тусгай шаардлагыг хангасан эсэх нь тодорхойгүй байна. Энэ нь одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулийг бус төсвийг дагуулж тусгай шаардлагыг өөрчлөх хандлагыг буй болгож байна.

3. Төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн хуулийн өөрчлөлт оруулахдаа үндэслэл, тооцоо судалгааг сайжруулах шаардлагатай байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1.6, 12.1.7 дахь заалтад өөрчлөлт оруулах тухай болон 4 дүгээр зүйлийн 4.1.12, 4.1.13 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.9 дэх хэсгийг тус тус хүчингүй болгох санал болгож буй өөрчлөлт нь ерөнхийдөө төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн гэж үзэж болохоор байгаа ч анхаарах шаардлагатай зүйлүүд, учирч болзошгүй эрсдэлүүд өндөр байна. Тиймээс төсвийн тусгай шаардлага, ДХТХМ-ийн үзүүлэлтэд өөрчлөлт оруулахдаа төсвийн тогтвортой байдал, төсвийн бодлого, макро эдийн засгийн ач холбогдлыг сайтар харгалзан үзвэл зохино.

4. Төсвийн тогтолцоог сулруулах өөрчлөлт хийх хандлага үргэлжилж байна. Хуулийн төсөлд тусгагдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийг хүчингүй болгох нь ДХТХМ-ийг баталснаас хойш гурваас доошгүй сарын хугацаанд харгалзах тухай жилийн төсвийн төслийг өргөн мэдүүлэх, батлахыг хориглосон хуулийн хамгаалтыг үгүй хийж байгаа учраас хэвээр үлдээх хэрэгтэй гэж үзэж байна.

5. Голлох эрдсийн бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнийн төсөөлөл зах зээлийн орчин, нөхцөлтэй нийцтэй бус байна. Хуулийн төсөлд 2026 онд нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 133.7 ам.доллар, зэсийн үнийг 8,341.8 ам.доллар байхаар өмнө жил төсвийг төслийг өргөн мэдүүлсэнтэй адил байхаар тооцжээ. Харин өнөөдөр нүүрсний хилийн үнэ 68 ам.доллар, зах зээлийн 131.9 ам доллар байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцохдоо Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11.1.3.а-д заасны дагуу "... Олон улсын валютын сангаас гаргасан түүхий эдийн үнийн статистикт тусгасан тухайн төсвийн жилийн өмнөх дараалсан харгалзах 20, 19, 18 жилийн дундаж үнэ, эрдэс баялгийн үнийн төсөөллийг мэдээлдэг олон улсад нэр хүнд бүхий, Засгийн газраас тодорхойлсон санхүүгийн мэдээллийн байгууллагаас тухайн жилийн гуравдугаар сард анх зарласан өдрийн тухайн төсвийн жилийн болон түүний дараах гурван жилийн дундаж үнийн төсөөллийг дундажлан тус тус тооцох" мөн хуулийн 11.1.3.б-д заасны дагуу "... гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийн тооцоонд алтны тухайн төсвийн жилийн өмнөх дараалсан харгалзах жилүүдийн дундаж үнийг тусгахдаа эрдэс баялгийн үнийн төсөөллийг мэдээлдэг олон улсад нэр хүнд бүхий, Засгийн газраас тодорхойлсон

санхүүгийн мэдээллийн байгууллагаас гаргасан статистикт тусгасан үнийн дунджаар тооцох” хуулийн зохицуулалттай байгаа нь зарим жилүүдэд гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ бодит үнээс хэт ялгаатай тогтох нөхцөлийг бүрдүүлж байна. Иймд цаашид орлогыг бодитой тооцох шаардлагад нийцүүлэн тэнцвэржүүлсэн үнийг тооцох аргачлалыг өөрчлөх шаардлагатай.

6. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүд дутуу, буруу томъёололтой хэвээр байна. 2010-2026 онд Төсвийн тухай хуульд 71 удаа, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 22 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан нь эдгээр хуулийн уялдаа, нэгдмэл байдал, зохицуулах чадварт сөргөөр нөлөөлж, төсвөө хүрээ нь дагадаг, тодотгол хийж, төсвийн орлого, зарлага буурсан үед ч хүрээ нь хөндөгддөг нөхцөлд хүрсэн байна. Иймээс эдгээр хуулиудын нийцлийг эргэн харж тодорхой өөрчлөлт оруулах, дараах үзүүлэлтийг ДХТХМ-д тусгаж байх нь зүйтэй байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд ордоггүй, төсвийн төлөвлөлт болон тусгай шаардлагуудад шууд хамааралтай үзүүлэлтүүд

ДХТХМ-д багтаагүй үзүүлэлтүүд	ДХТХМ-д нэмж оруулах үндэслэл
Нэрлэсэн ДНБ	Төсвийн тусгай шаардлагууд нэрлэсэн ДНБ-д эзлэх хувиар илэрхийлэгдэн хуульчлагдсан.
Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал зардал	Төсвийн тусгай шаардлагад туссан.
Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого	Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, бодлогын бичиг баримтад тусгагддаг.
Голлох эрдсийн бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнэ	Төсвийн тусгай шаардлага болох тэнцвэржүүлсэн орлого болон тэнцвэржүүлсэн тэнцлийг тооцоход ашиглагддаг.

7. ДХТХМ-д өөрчлөлт оруулахдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тусгагдсан заалтуудыг баримтлах шаардлагатай. ДХТХМ-д өөрчлөлт оруулах тохиолдолд хуулийн төслийг өргөн барихдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.6 дахь заалтын дагуу “Засгийн газар ДХТХМ-ийн төслийг энэ хуулийн 16¹.5.1-д заасан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн боловсруулаагүй бол түүний үндэслэл, шалтгааныг үзүүлэлт тус бүрээр бодлогын өөрчлөлтөөр тодорхойлж тайлбарлан, уг тайлбарыг ДХТХМ-ийн төслийн хамт өргөн мэдүүлнэ.”, 12.3 дахь хэсгийн ДХТХМ нь дараах агуулгатай байна:” гэсэн заалтуудын хэрэгжилтийг хангах шаардлагатай байна.

8. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд “Төсвийн тусгай шаардлага” гэсэн нэр томъёог өөрчлөн олон улсын жишиг стандарттай нийцүүлэн “Төсвийн дүрэм” гэсэн нэр томъёо, ойлголтыг хэрэглэх, энэ талаар хуулийн төсөлд тусгах, дүрмийн тогтвортой байдал, хэрэгжилтийг хангах нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй.

9. Урсгал зарлага ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй гэсэн хязгаарлалт хэдий өндөр түвшин ч улсын төсвийг “хэтэрхий том хэрэглээний хөөс” болохоос хамгаалж байсан сүүлчийн ганц хаалт байсан. Үүнийг цуцалснаар төсөв хөгжлийн хэрэгсэл бус, зөвхөн сонгуулиас сонгуулийн хооронд бэлэн мөнгө, халамж тараадаг улс төрийн хэрэгсэл болон хувирах томоохон хор уршигтай юм. Иймд энэхүү заалтыг өргөн барьсан хэлбэрээр хэлэлцсэн тохиолдолд “6.1.3. тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль багын хоёرنы нэгээс хэтрэхгүй байх” гэж өөрчлөх нь ДНБ-ий өсөлтөөс давсан төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлахад эерэг нөлөөтэй гэж үзэж байна.

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ